

ASA “АС-АРВАЙ АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 7 сарын 8-дөрөн

No 22

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Зоос гоёлын байр, 208 тоот
Утас: 99110691, 70115359

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМ (“МУНН”)ЫН УДИРДЛАГАД

Бид “МУНН”-ын (цаашид “Нам” гэх) УИХ-ын 2016 сонгуулиар иргэд, хуулийн этгээдээс хүлээн авсан хандив, түүний зарцуулалтын тайланд аудит хийлээ.

Удирдлагын үүрэг хариуцлага

Энэхүү санхүүжилт, зарцуулалтын тайланг Монгол улсын холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн үнэн зөв бэлтгэж, толилуулах нь намын удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүжилт, зарцуулалтын тайланг алдаа зөрчилгүй бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, түүнийгээ хэрэгжүүлэн, түүнийгээ туштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиromжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан энэхүү санхүүжилт зарцуулалтын тайлангийн талаар аудитын дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүжилт зарцуулалтын тайлан дахь дүн болон тодорууллын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурilan сонгодог бөгөөд үүнд, залилан, юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцооллыг хийхтэйгээр холбоотойгоор, аудитор намын дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор намын санхүүгийн үйл ажиллагааны тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлхээс гадна, намын удирдлагын зүгээс хийсэн томоохон

тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиromжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэдэгт бид итгэж байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАНГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

Дүгнэлтийн тайлбар

МУНН нь 2016 оны УИХ-ын сонгуульд нийт 11 хүн дэвшүүлсэн ба иргэдээс 3,277,680 төгрөгийн хандивийг УИХ-ын 51-р тойрогт нэр дэвшигч Батдэлгэрийн Батболдын нэр дээр шилжүүлснийг үндэслэн тус нэр дэвшигч Б.Батболдын сонгуулийн зардалд 3,200,000 төгрөгийг зарцуулсан гэж бидэнд мэдээлсэн. Үүнээс УИХ-д нэр дэвшигчдийн хувисаа гаргасан сонгуулийн зардал ба түүний эх үүсвэрт аудит хийх захиалгыг бид хүлээж аваагүй учраас нэр дэвшигчдийн сонгуулийн хандив зарцуулалтын талаар дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, дүгнэлтийн тайлбар хэсэгт дурьдсан зүйлсийг харгалзан үзсэн тохиолдолд энд хавсаргасан санхүүжилт зарцуулалтын тайлан нь УИХ-ын сонгуулийн үеэр хүлээн авсан хандив ба түүнд зориулсан зарцуулалтын санхүүгийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн байна. Түүнчлэн энэхүү санхүүжилт зарцуулалтын тайландаа тусгагдсан санхүүжилт болон зарцуулалтууд нь хангалттай бөгөөд хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

АС
АУДИТ
ХХК

С.Андреш

С.АНДРУШ

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМ

**УИХ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛИЙН ХУГАЦААНЫ
САНХҮҮГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ**

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

1993 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Монголын Хувийн Өмчтөний нам, Монголын Малчин Тариачны нам, Монголын Тусгаар Тогтолын намууд нэгдсэн анхдугаар чуулганаа хийж, Монголын Уламжлалын Нэгдсэн Намыг үүсгэн байгуулсан.

Тус нам туйлын зорилгоо “Монголын улсад Ерөнхийлөгчийн засаглал тогтоож, биеэ даасан бодлого явуулдаг, олон сая хүн амтай, онгон сайхан байгалтай, уламжлал, түүх, соёлоо дээдэлдэг, хүчирхэг, баян тансаг Монгол улсыг буй болгож, түүний тогтвортой хөгжих нөхцлийг бүрдүүлэхэд оршино” хэмээн тодорхойлсон.

МУНН-ын бусад намаас ялгагдах онцлог шинж нь ихэвлэн цэрэг, хүцний байгууллагад ажиллаж байсан хүмүүсээс гишүүдийн цөм нь бүрддэг ба цэвэр үндэсний эх оронч үзэл дээр нэгдсэн. “Монгол хүн Монгол газар шороондоо эзэн нь байх ёстой” гэсэн уриатай.

Намын эрх барих дээд байгууллага нь намын их хурал, их хурлын чөлөөт цагт их хурлаас сонгогдсон Улс Төрийн Ерөнхий Зөвлөл, намын тэргүүлэгчид намын үйл ажиллагааг удирдан явуулдаг. Намын өдөр тутмын үйл ажиллагааг намын тамгын газар, нийслэл, дүүрэг, аймаг бүсүүдийн нарийн бичгийн дарга нар эрхлэн явуулдаг.

МУНН-ын төв нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 1 дүгээр Хороо, Элчингүүдийн гудамж дахь Мика зочид буудлын А корпуст байрладаг.

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМ

УИХ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛИЙН ХУГАЦААНЫ
САНХҮҮГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГДЭЛ-ҮРГЭЛЖЛЭЛ

Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй

Тус нам нь санхүүжилт зарцуулалтын тайлан бэлтгэхдээ дараах бүртгэлийн бодлогуудыг баримталсан.

Даган мөрдөх тайлан

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан бэлтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн тухай Монгол улсын хууль болон энэ хуультай нийцүүлэн Сангийн яамнаас баталсан холбогдох заавар журам, аргачлалыг даган мөрдсөн.

Тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайлангуудыг нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртгийн суурьд үндэслэн, Монгол улсын мөнгөний нэгж болох төгрөгөөр илэрхийлэн бэлтгэсэн.

Санхүүжилт

Гишүүд дэмжигчдээс хүлээн авсан хандивыг хүлээн авсан үед нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн сууриар үр дүнгийн тайланда хүлээн зөвшөөрдөг. Санхүүжилтийг намын үйл ажиллагааны зориулалтаар зарцуулж, гарсан зарцуулалтыг үр дүнгийн тайланда зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Сонгуулийн үйл ажиллагааг зориулсан яамнаас гарсан зардлыг намын ерөнхий нарийн бичгийн дага хянаж, санхүүжилт зарцуулалтын тайланда тусган Сонгуулийн ерөнхий хороонд тайлагнадаг